*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ БАДАМДОРЖИЙН ДОРЖПҮРЭВИЙН

## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 1. | Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангаж | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой 188 мэдээ, 312 пост мэдээллийг түгээсэн. Хэвлэлийн бага хурал 5 удаа. | 1.Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж, нийт түгээсэн мэдээ мэдээллийн тоо суурь түвшинөөс өссөн байна.<br>2.Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй ташаа мэдээлэл, нийгмийн үнэлэмжийг бууруулах сөрөг мэдээллүүдэд удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу хариу арга хэмжээг авна.<br>3.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр | 1. "Монголын гааль" хуудас 2023 онд 21.1 мянган дагагчтай байсан бол 2024 оны 12 сарын 08-ны байдлаар 27 мянган дагагчтай болж өмнөх оноос 28% өссөн байна. Монголын гааль пэйжид өмнөх онд 312 пост мэдээлэл нийтэлсэн бол энэ онд 409 пост мэдээллийг түгээсэн нь өмнөх оноос 97-оор буюу 31%-иар өссөн байна. https://www.customs.gov.mn/ вэб хуудсанд өмнөх онд 188 мэдээ, мэдээлэл нийтэлсэн бол энэ онд 283 мэдээ, мэдээллийг нийтэлж өмнөх оноос 95-аар буюу 103,4% өссөн<br>2. Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээллийг ажлын өдрүүдэд, өдөр бүр 4 удаагийн давтамжтай шүүлт хийн тухай бүрд нь "Гаалийн хэвлэлийн тойм" вайбер группд байх ЗББДБ-ын 33 дарга удирдлагад шууд танилцуулж, тухай бүрд нь чиглэл авч | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажилласан байдал | | | гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ. Удирдлагыг тухай бүрд нь мэдээллээр хангаж ажилласан байна. | ажилласан. Эдгээр мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд өмнөх онд гаалийн байгууллагатай холбоотой нийт 1539 мэдээ, мэдээлэл илэрсний 201 мэдээ нь ОНХА-аас бэлтгэн түгээсэн гаалийн эх сурвалжтай мэдээ байсан бол 2024 онд 3029 мэдээлэл илэрснээс 409 мэдээ нь ОНХА-аас бэлтгэсэн гаалийн эх сурвалжтай мэдээ байв. Энэ нь гаалийн эх сурвалжтай мэдээ, мэдээлэл олон нийтэд хүрэх байдал өмнөх оноос 103.4 хувиар өссөн үзүүлэлтийг харуулж байна.<br>3. Удирдлагыг өдөр бүр мэдээллээр хангаж чиглэл авч ажилласан. Үүний үр дүнд Энэ онд гарсан сөрөг мэдээллийг залруулж олон нийтэд зөв, эерэг мэдээлэл өгөх зорилгоор 4 удаагийн хэвлэлийн бага хурал, нээлттэй хаалганы 4 удаагийн өдөрлөгийг хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулсан нь өмнөх оноос 0,6%-иар өсжээ. | | |
| 2. | Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мэдээлэл солилцох, байгууллагыг төлөөлөн хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | 1.Хэвлэл мэдээллийн 20 байгууллагатай хамтын ажиллагаатай.<br>2.Чиг үүрэг хариуцсан нэгжтэй хамтран олон нийтэд түгээх шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулан ажилласан.<br>3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө сургалтыг 4 удаа зохион байгуулсан. | 1.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нээлттэй хамтран ажиллаж, байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангасан байна.<br>2. Чиг үүрэг хариуцсан ЗББНДБ, харьяа газар, хороодтой хамтран олон нийтэд түгээх шаардлагатай мэдээ, мэдээллийн төлөвлөөг авч нэгтгэн, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр боловсруулан ажиллана. | 1. ОНХА телевизийн 20 гаруй байгууллагатай, 30 гаруй вэб сайт, өдөр тутмын 3 сонинд мэдээ мэдээлэл нийтлүүлж, 8 удаа сөрөг мэдээлэлд хариу тайлбар мэдээллийг өгч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдээс ирсэн 70 гаруй хүсэлтийг утас, фэйсбүүк чат болон Viber, бусад сувгаар нээлттэй байдлаар хүлээн авч шийдвэрлэсний үр дүнд гаалийн байгууллагын нээлттэй ил тод байдлын талаар гомдол гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч гараагүй байна. ОНХА-аас бэлтгэн боловсруулсан 409 мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группууд руу түгээж ажилласан. | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх 2 удаагийн сургалтаар 160 албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч сургалтыг зохион байгуулсан байна. | - Телевизээр цацагдсан мэдээ мэдээллийн тоо 230, мэдээллийн сайтаар гарсан мэдээллийн тоо 311, сонинд нийтлэгдсэн мэдээний тоо 45 байна.<br>2. Чиг үүрэг хариуцсан ЗББНДБ-аас авсан саналыг байгууллагын удирдлагад танилцуулж өгсөн чиглэлийн дагуу мэдээлэл бэлтгэх төлөвлөгөө гарган ажилласан. 1-р улирлын төлөвлөгөөт саналаас шаардлагатай 28 ажил, 2-р улиралд 25 ажил, 3-р улиралд 26 ажил, 4-р улиралд 30 ажлыг тус тус удирдлагаас чиглэл аван баталгаажуулж, 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, мэдээ мэдээллийг түгээсэн.<br>СЭГГ, ЗҮГГ-т томилолтоор ажиллаж Үүрэг хүлээсэн гаальчин нэвтрүүлгийн 2 дугаар, тус гаалийн газрын үйл ажиллагааг сурталчилсан 7 мэдээ мэдээллийг боловсруулан түгээж ажиллав.<br>3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх 8 удаагийн сургалтаар 542 албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулсан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал сургалтын тоо 4 дахин өссөн байна. Мөн видео яриа, рийлийн бичлэг хийлгэж байгаа алба хаагчдын 80 хувьд дадлага хийж суралцах боломжийг олгож, тус бүр 2-3 бичлэг хийлгэх ганцаарчилсан сургалтад хамруулж ажилласан. | | |
| 3. | Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | 1.Байгууллагын цахим хуудсыг тогтмол хөтөлж хөгжүүлж, Цахим хөгжлийн яаманд 2022 оны ажлаа “А” үнэлгээтэй амжилттай дүгнүүлсэн. | 1.Байгууллагын цахим хуудсыг тогтмол хөтөлж хөгжүүлж, Цахим хөгжлийн яаманд 2023 оны ажлаа 95 хувиас дээш “А” үнэлгээтэй дүгнүүлнэ. | 2023 онд www.customs.gov.mn вэб сайтыг цахим хөгжлийн яамнаас "А" үнэлгээтэй үнэлсэн бол энэ онд шил ажиллагааны тайланг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Цахим хөгжлийн яамны Shilen.gov.mn сайтад | 2024.01.01 - 2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2.Байгууллагад хамаарах, хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад 26 мэдээллийг үнэн зөв, ил тод байршуулсан.<br>3.Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэл 50 хувьтай хийгдсэн. | 2.Байгууллагад хамаарах, хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ЗББНДБ-уудаас авч тухай бүр нь үнэн зөв, ил тод байршуулна.<br>3.Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэл 60 хувиас дээш хийгдсэн байна. | үнэлүүлэхээр илгээсэн. Хариу 2024 оны 12 сард гарна.<br>2. Төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах хүрээнд үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал, авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр 36 мэдээллийн байршуулсан байна.<br>3. Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэл 90 хувиас дээш хийгдсэн байна. 19 газар хороодын веб сайтын шинэчлэлт бэлэн болж, ажиллаж байгаа. Төлөвлөснөөс 25% илүү байна.<br>Төрийн байгууллагуудын цахим хуудас нэг загвар, стандарттай болж байгаа тул нэгдсэн нэг сайтад ГЕГ-ын 2023, 2024 оны мэдээллийн баазыг сайтруу байршуулах ажил болон хийгдэж байна | | |
| 4 | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой видео танилцуулга, хэвлэлийн эх бэлтгэсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | .Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 67 бичлэг, видео, 120 постер, 125 зураг, гааль сэтгүүлийн хэвлэлийн эх бэлтгэсэн | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бичлэг, видео, постер, зураг бэлтгэн, удирдлагуудад танилцуулан нийтэд хүргэсэн байна. | 2023 онд гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 312 бичлэг, видео, постер, зураг мэдээ, мэдээлэл бэлтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан түгээсэн бол 2024 онд энэ тоо 409 болж өмнөх оноос 97-оор буюу 31%-иар өссөн байна. Мөн баяр наадам, хурал зөвлөгөөн, бусад арга хэмжээнд зориулж 24 баннер, урилга, зурагт хуудас бэлтгэсэн нь өмнөх оноос 12%-иар өссөн байна.<br><br>Мөн зураглаач эвлүүлэгчээр ажиллаж байгаа албан хаагчдаа бие даан суралцах боломжоор хангаж мэдээлэл түгээх шинэ төрөл болох лайв, рийлийн бичлэг хийх ажлыг туршиж эхэлсэн. Энэ онд 3 лайв бичлэг хийж, 4 линкээр судалгаа авч, 38 рийл мэдээ, мэдээлэл бэлтгэн удирдлагуудад танилцуулан нийтэд хүргэсэн нь Монголын | 2024.01.01<br>-<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гааль пэйж хуудасны дагагчийн тоо өмнөх оноос 28% өсөхөд голлон нөлөөлсөн бөгөөд 12-р сарын 08-ны байдлаар рийл бичлэгийн үзэлт буюу хандалт өдөрт дунджаар 212 мянга болж нэмэгдсэн байна. | | |
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Олон нийттэй харилцах албаны үйл ажиллагаанд хамааралтай бодлогын баримт бичгүүд байгаагүй болно. | Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой үүрэг даалгавар 2024 онд ОНХА-нд өгөөгүй.<br>Сангийн яамны 2024 оны шуурхай хуралдаанаас гаалийн байгууллагад өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг хугацааны хоцрогдолгүй 100 хувь биелүүлэн ЗУГ өгч ажилласан. | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |
| 6 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжилтийг хангаж ажиллан, хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | Олон нийттэй харилцах албаны холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан талаар тайлагнана. | ОНХА нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж Гаалийн байгууллагын олон нийтэд нээлттэй байх зорилтыг хангаж ажилладаг.<br><br>ХАСХОМ-ыг 2024 оны тайланг хуулийн хугацаанд холбогдох баталгааны маягтын дагуу гарган ХНХ-д хүлээлгэн өгч, 100 хувь баталгаажуулсан.<br><br>ДГБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Гаалийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, ЗГ-аас хэрэгжүүлж байгаа цахимжилт, "Шуур", "Шугэл" ажиллагаа, авлигатай тэмцэх хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, аяны хүрээнд 11 төрлийн "Авлигын эсрэг нэгдье, Үгүй гэж хэлээд өөрчилье" уриатай соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг Гаалийн байгууллагын албан ёсны хуудас “Монголын гааль” фэйсбүүк пэйж хуудаснаас түгээж, олон нийтэд | 2024.01.01 - 2024.12.10 | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурталчилсан. АТГ-тай хамтран гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 3 минутын видео шторкыг бэлтгэсэн. Мөн "ГЕГ-ын авилгийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллийг эрчимжүүлж холбогдох хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор "Гаалийн шинэчлэл-Үр дүн 2024" зорилтот контентуудыг үе шаттай бэлтгэн түгээх ажлыг зохион байгуулав. | | |
| 7 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Шинээр 2024 онд нэмэгдсэн шалгуур үзүүлэлт тул 2023 онд төлөвлөгөөгүй. | Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэнэ. | 1.Гаалийн байгууллагын нэр хүнд, олон нийтэд цацагдаж буй мэдээ мэдээлэлд мониторинг хийж болзошгүй эрсдэлийг тооцон удирдлагад тухай бүр нь танилцуулж энэ онд 14 удаагийн хариу арга хэмжээг зохион байгуулж шаардлагатай тохиолдолд тайлбар мэдээллийг түгээж ажиллав.<br>2. Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэв. Түүнд дүн шинжилгээ хийж 2024 онд нэгжийн эрсдэлийг 30.7 хувь бууруулав.<br>Бууруулсан эрсдэлийг санд дараах эрсдэлийг бүртгэж, үр дүнг тайлагнав. Үүнд:<br><br>- Албан хаагчдын интернэтийн хурд хангалтгүйгээс шалтгаалж (2 ярилцлага видео мэдээлэл татах хурд 4 цаг орчим байсныг МТТ-тэй хамран 20 мин орчим болгож бууруулсан) эрсдэлийн энэ оны 9 сард шийдвэрлэн ажлын бүтээмжийг 12 дахин нэмэгдүүлэв.<br>- Дизайнерын компьютерыг шинэчилснээр ажлын бүтээмж 10 дахин нэмэгдэж, видео мэдээлэл боловсруулахад суралцаж хөгжих боломжийг олгосон.<br>- Видео камер, тэнцвэржүүлэгч хөл зэрэг орчин үеийн тоног төхөөрөмжийг шинэчилснээр бусад хэвлэл мэдээллийн | 2024.01.01<br>-<br>2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгслүүдэд мэдээлэл түгээхэд техникийн болон чанарын шаардлага хангадаг болсон. Энэ нь гаалийн эх сурвалжтай мэдээлэл нэмэгдэж, албан хаагчдын техник хэрэгслээс шалтгаалсан ажлын цаг ашиглалт 2 дахин сайжирсан байна.<br>- Хүний нөөцийн хувьд дутуу буюу нэг албан хаагчид оногдох ачаалал өндөр байсныг шийдвэрлэж орон тоог бүрэн гүйцээн нөхөн хангасан. | | |
| 8 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Нийт 6 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь 100 хувь оруулж ажилласан. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан талаар тайлагнана. | 1.Гаалийн цом 2024 спортын наадмын нээлтийн, хаалтын үеэр бичлэг хийсэн, мөн бүх тоглолтыг live хийсэн.<br>2.Бүрдүүлэлтийн нэгдсэн төв, цахим бүрдүүлэлттэй холбоотой үйл ажиллагааг гаалийн байгууллагаар үйлчлүүлдэг иргэн, аж ахуй нэгж нарт сурталчлах ажлын хүрээнд цахим, пэйж хуудсаар дамжуулан мэдээ, мэдээллийг постер, видео шторк хэлбэрээр хүргэсэн. | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |
| 9 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2024 оны ажлын цаг ашиглалт 84 хувьтай байсан. | Ажлын цаг ашиглалтыг албан хаагчдын цагийн бүртгэлийн програмад тухай бүр бүртгүүлж, бүртгүүлээгүй тохиолдолд хүсэлтийг холбогдох нэгжид хүргүүлэн, өмнөх оноос сайжруулсан байна. | Ажлын цаг ашиглалтыг сайжруулан ажиллаж байна. | 2024.01.01 - 2024.12.10 | 95 |
| 10 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Харьяа гаалийн газар хороодод 2 албан бичгээр чиглэл, зөвлөмж хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан.<br>2.Тус газрын албан хаагчдаас цаг үеийн шинжтэй нийт 1 ажлын | 1.ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу хамтран ажилласан байна.<br>2.Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, нэгжийн үйл ажиллагаанд | 1. Албан хаагчид 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд АТГ-т мэдүүлэн, ГЕГ-ын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.<br>2. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын эрэлч нохой хариуцсан ГУБ Б.Уранчимэгийн оролцсон "Үүрэг хүлээсэн гаальчин" видео контентийн зураг авалтыг хийсэн. | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байна. | ашиглагддаг программын шинэчлэлт, хөгжүүлэлт, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан болон бүрэлдэхүүнд нь ажилласан байдал, аливаа зөвлөмжийн биелэлтийг хангана. | 3. Замын Үүд дэх гаалийн газрын эрэлч нохой хариуцсан ГУБ Б.Энхтайван оролцсон "Үүрэг хүлээсэн гаальчин" видео контентийн зураг авалтыг хийж эвлүүлэг хийсэн.<br><br>3. Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, гаалийн цом-2024 тэмцээний шууд лайв, тэмцээний тухай мэдээллийг тухай бүрт нь “Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп” оруулж нийт ГУБ нарт түгээсэн.<br>4.Тэрбум мод үндэсний хөтөлбөрт нэгдэж Хөшгийн хөндийд байрлах эрэлч нохойн сургалтын төвд мод тарих үйл ажиллагааны видео бичлэгийг монтажлан “Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп”, “монголын гааль” цахим хуудаст, customs.gov.mn веб сайтад байршуулсан.<br>5. Гэрэлт-ирээдүй хүүхдийн баярын үйл ажиллагаанд Олон нийттэй харилцах алба ажлын хэсгээр оролцож ажилласан.<br>6. ОНХА-наас Фэйсбүүкээр дамжуулан 244 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”, 153 гишүүнтэй “Сэтгүүлч”, 247 гишүүнтэй “Хэвлэлийн төлөөлөгч”, 95 гишүүнтэй “Гаалийн мэдээ, мэдээлэл”, 249 гишүүнтэй “Хэвлэлийн бага хурал”, вайберын 44 гишүүнтэй “Гаалийн хэвлэлийн тойм”, 248 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”гэх мэт хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группт мэдээ, мэдээллийг ашиглаж болох байдлаар түгээн ажилласан.<br>7. АТГ-тай хамтран хэрэгжүүлсэн авлига хүнд суртлаас ангид байх сурталчилгааны ажилд видео контент бэлтгэн оролцов.<br><br>8. Гаалийн лавлах 1800-1281 утсаар иргэд олон нийтээс мэдээлэл лавалгаа авах болон харьяа гаалийн газар хороод гомдол, санал | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүсэлтийг сегр програмд хэрхэн бүртгэх талаарх видео заавар<br>9. Таны асуултад хариулъя 3 төрлийн видео:<br>- Тээвэрлэгч байгууллагад олгодог "ГААЛИЙН ИТГЭМЖЛЭЛ"-ийн хүсэлтийг цахимаар хэрхэн шийдвэрлүүлэх вэ.<br>- Гадаад Улсаас ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТАН улсын хилээр нэвтрүүлэхэд иргэн та дараах шаардлагыг хангасан байна<br>- "АВТОМАШИНЫ ГААЛИЙН ҮНЭ"-ийг хэрхэн тогтоодог вэ. | | |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт / Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах ажил хийгдэж байгаагүй. | 1.Гаалийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд дохионы хэлний хэлмэрчтэй гэрээ байгуулна.<br>2.Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний танилцуулга бүхий брошюрыг брайл дээр хэвлүүлэх гэрээг байгуулна. | 1. АТГ-тай хамтран гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 3 минутын видео шторкны баруун доод хэсэгт дохионы хэлний хэлмэрч С.Бямбадэлгэрийг видео хэлбэрээр оруулсан. Тус видео контентод ГЕГ-ын ОНХА-ны дарга Б.Мөнх-Амар хөтлөгчөөр ажилласан. Энэ контентыг гаалийн байгууллагын “Монголын гааль” пэйж хуудас, “Монголын гааль” твиттер, customs.gov.mn вэб хуудас, youtube хуудсанд байршуулан гадаад худалдаа эрхлэгч, иргэд болон, олон нийтэд түгээсэн.<br>Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо ТББ-тай гэрээ байгуулж хамтран ажиллаж байна. Гэрээний хүрээнд дараах мэдээллийг дохионы хэлээр орчуулж олон нийтэд хүргэсэн. Үүнд.<br>- “Боомтын шинэчлэлийн үр дүн боршоо боомтод” 1 минут 38 секундын видео<br>Хандалт 212<br>- Боомтын шинэчлэлийн үр дүн Замын-Үүд боомтод” 2 минут 08 секундын видео<br>Хандалт 1,700<br>2. Хараагүйчүүдийн үндэсний төвд ЗОРЧИГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЭД ЗҮЙЛИЙГ ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ-ыг брааль үсгээр хэвлүүлсэн. Энэ нь брааль стандартын хэмжээгээр 19 хуудас | 2024.01.01 - 2024.12.10 | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүхий 40 ширхэг ном, нийт 760 хуудас материал хэвлүүлж, 19 харьяа гаалийн газар хороодын орох, гарах чиглэлд байршуулахаар түгээгдсэн. | | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан/ | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн нийт 17 шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг "Монголын гааль" цахим хуудсанд нийтэлсэн мэдээллийг харьяа 18 гаалийн газар, хороод албан ёсны цахим хуудсандаа татан авч, олон нийтэд хүргэсэн.<br>2.Албан хаагчдыг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2 төрлийн сурталчилгааны материалыг хийж, харьяа 18 гаалийн газар, хороодод хүргүүлэн цахим хуудас болон "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарт хэвлэмэл байдлаар байршуулан олон нийтэд хүргэн ажилласан.<br>3.Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент хийж байгаагүй. | 1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг тогтмол байршуулж, олон нийтэд сурталчилсан байна.<br>2. 1 видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байна | 1. "ГЕГ-ын авилгийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд гаалийн хууль тогтоомж, үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг эрчимжүүлж олон нийтэд түгээх сурталчлах зорилгоор "Гаалийн шинэчлэл-Үр дүн 2024" зорилтот контентуудыг үе шаттай бэлтгэн түгээх ажлыг зохион байгуулав. Эдгээр зорилтот мэдээлэл нь Монголын гааль пэйж хуудасны дагагчийн тоог өмнөх оноос 28% өсөхөд голлон нөлөөлж байгаа бөгөөд 12-р сарын 08-ны байдлаар эдгээр зорилтот ажлын хүрээнд бэлтгэсэн контентын хандалт өдөрт дунджаар 212 мянга болж нэмэгдсэн байна.<br><br>2. 3 видео контент бүтээж монголын гааль фэйсбүүк цахим хуудас, customs.gov.mn веб сайтад байршуулсан.<br>Үүнд: Иргэн та гаалийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнд хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн тохиолдолд Авлигатай тэмцэх газрын "110" тусгай дугаарт мэдэгдэнэ үү. Мөн, боомтын шинэчлэлийн үр дүн Боршоо, Замын үүд боомтод<br><br>3. Шинээр томилогдох албан хаагчдыг Авлигын эсрэг хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн сургалтын зураг авч пэйж болон цахим хуудсанд мэдээлэл оруулсан. | 2024.01.01<br>-<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан/ | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | “Бидний нэг” гаалийн албан хаагчдыг сурталчилсан видео контент 2 дугаар хийсэн. | Гаалийн байгууллагын олон нийтэд хүргэх мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, улирал бүр нэвтрүүлэг бэлтгэн гаргаж,олон нийтэд хүргэх мэдээллийн тоог өмнөх оныхоос 5-аас доошгүй хувиар өсгөнө. | Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 4 нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэв. Үүнд:<br><br>1. “Үүрэг хүлээсэн гаальчин” гаалийн албан хаагчдыг сурталчилсан видео контентын энэ оны эхний дугаарт СЭГГ-ын эрэлч нохой хариуцсан ГУБ Б.Уранчимэг оролцсоныг 5-р сарын 23-нд олон нийтэд түгээсэн.<br>2. УХШИГГ-ын ГУБ Болдбаатар оролцсон. Энэ дугаарыг улсын их баяр наадмын өмнө олон нийтэд түгээхээр бэлтгэж байна. 7 дугаар сарын<br>3. ГЕГ-ын Гаалийн төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд оролцсон. Энэ дугаарыг 10 дугаар сарын 20-нд олон нийтэд түгээж ажилласан байна.<br><br>Үүрэг хүлээсэн гаальчин видео контентын 4 дэхь буюу сүүлийн дугаарт ЗҮГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ Б.Энхтайван оролцсон. | 2024.01.01 - 2024.12.10 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар болон зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг цаг хугацаанд нь программд оруулж ажилласан байна. | Өдөр тутамд дарга, ГУАБ-аас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлэн ажилласан. | 2024.01.01-2024.12.10 | 96 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Гаалийн улсын байцаагчийн мэргэжлийн түвшин тогтоох шалгалтад бэлдэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Англи хэл бие даан сурч, хэлний мэдлэгээ дээшлүүлсэн. | Англи хэлний сургалтад хамрагдан мэдлэгээ дээшлүүлсэн байна. | SPEAKING MASTERS хөтөлбөрт хамрагдсан. Уг хөтөлбөр нь TESOL/TEFL зэрэгтэй, 6+ жилийн туршлагатай ярианы багш, арга зүйч багш Энхболорын 2 сарын цахим хичээл юм. | 2024.01.01-2024.12.10 | 100 |
| 2 | Сургалтад хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Сэтгүүлчийн сургалтад хамрагдсан. | Гаалийн хэргийн мэдлэг, ур чадвараа сайжруулсан байна. | Сошиал орчин дахь маркетинг 2 өдрийн онлайн сургалтад хамрагдсан. Хэвлэлийн төлөөлөгч ТББ-аас зохион байгуулсан. | 2024.01.01-2024.12.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ — Б.ДОРЖПҮРЭВ /......................... / — 2024.12.10

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ ДАРГА — Б.МӨНХ-АМАР /................................/ — 2024.12.10

*(Нэр, гарын үсэг)* — *(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ БАДАМДОРЖИЙН ДОРЖПҮРЭВИЙН
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Олон нийттэй харилцах алба

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх** | | | | | |
| 1. | Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байдал | 59 | 10 | 69 | |
| 2. | Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мэдээлэл солилцох, байгууллагыг төлөөлөн хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал | 59 | 10 | 69 | |
| 3. | Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх | 59 | 10 | 69 | |
| 4. | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой видео танилцуулга, хэвлэлийн эх бэлтгэсэн байдал | 59 | 10 | 68 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 59 | 10 | 69 | |
| 6. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | 59 | 9 | 68 | |
| 7. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 59 | 9 | 68 | |
| 8. | Үүрэг даалгаврын биелэлт | 59 | 9 | 68 | |
| 9. | Ажлын цаг ашиглалт | 59 | 9 | 68 | |
| 10. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 59 | 10 | 69 | |
| 11. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт / Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан/ | 59 | 9 | 68 | |
| 12. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан/ | 59 | 10 | 69 | |
| 13. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан/ | 59 | 9 | 68 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 14. | Өдөр тутамд дарга, ГУАБ-аас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлэн ажилласан. | 59 | 10 | 69 | |
| **Дундаж оноо:** | | | | **68.5** | |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | SPEAKING MASTERS хөтөлбөрт хамрагдсан. | 100 | 15 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Уг хөтөлбөр нь TESOL/TEFL зэрэгтэй, 6+ жилийн туршлагатай ярианы багш, арга зүйч багш Энхболорын 2 сарын цахим хичээл юм. | | | |
| 2. | Сошиал орчин дахь маркетинг 2 өдрийн онлайн сургалтад хамрагдсан. Хэвлэлийн төлөөлөгч ТББ-аас зохион байгуулсан. | 100 | 15 | |
| **Дундаж оноо:** | | | **15** | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6.9 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 6.9 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 6.9 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 6.9 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6.9 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. Асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах ур чадвар | 6.9 | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар 2. Бүтээлч байдал | 6.9 | |
| 8 | Мэргэжлийн ур чадвар 3. Судалгаа, дүн шинжилгээ, дүгнэлт хийх ур чадвар | 6.9 | |
| **Дундаж оноо:** | | **6.9** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7.8 |
| 2. | Багаар ажиллах | 7.8 |
| 3. | Харилцаа | 7.8 |
| **Дундаж оноо: 7.8** | | |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | **68.5** |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | **15** |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | ***6.9*** |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | ***7.8*** |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *Байхгүй* |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **98.2** |

***Үнэлгээ өгсөн:*** **Нэгжийн дарга**

Олон нийттэй харилцах алба даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. / Б.Мөнх-Амар /

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.............................. *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын байцаагч .............................. / Б.Доржпүрэв /

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.............................. *(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. / Г.Энхтайван /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

XII/20, 2024 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч .............................. / Ө.Тэгшээ /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024. 12. 20 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Гаалийн ерөнхий газрын дарга .............................. / Р.Отгонжаргал /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

.............................. *(огноо)*

4